



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 449

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.2, 6.4.6 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 43,550,000.00 (дөчин гурван сая таван зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

2.Түр уурын зуухыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, засаж сэлбэн, угсарч суурилуулах, шинэчилж сайжруулах ажлыг зохион байгуулж, холбогдох зардлыг тооцон, данс бүртгэлд тусгахыг "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэнд зөвшөөрсүгэй.

3.Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

3.3 Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003043

21-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн
449 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙГ ДАНСНААС ХАСЧ, МОНГОЛПРОСЦЕТМЕТ ТӨРИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хүчин чадал	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)
1	Дулааны узелийн барилгын түр уурын зуух	2015	0.7мвт	3	14,516,666.60	43,550,000.00
Нийт дүн					14,516,666.60 (арван дөрвөн сая таван зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран мөнгө)	43,550,000.00 (дөчин гурван сая таван зуун тавин мянга)